

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙДЫН
ТУШААЛ

_____ оны ____ сарын ____ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

Мэдээний нэр төрөл, жишиг үнэ,
тариф батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллагын Агаарын навигацийн үйлчилгээ ба нисэх буудлын үйлчилгээний төлбөрийн талаар баримтлах бодлогын баримт бичиг “ICAO Doc 9082”, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн үйлчилгээнд ашиглах тусгай хэрэгцээний цаг агаарын мэдээний нэр, төрөл, жишиг үнэ, тарифыг хавсралтаар баталж, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Нисэхийн цаг уурын тусгай хэрэгцээний мэдээгээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчлэхдээ энэхүү үнэ, тарифыг мөрдөж ажиллахыг Ус цаг уур, орчны шинжилгээний газар, түүний харьяа байгууллагын төсвийн шууд захирагч нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (Э.Баттулга)-т үүрэг болгосугай.

САЙД

Б.БАТБААТАР

НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭНИЙ
НЭР ТӨРӨЛ, ЖИШИГ ҮНЭ, ТАРИФ

Д/д	Мэдээний нэр, төрөл	Мэдээний үнэ, тариф (төгрөг)
1	Буудал орчмын бодит ажиглалтын мэдээ (METAR, SPECI)	7,000.0
2	Буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ, 9 цаг (TAF)	14,000.0
3	Буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ, 30 цаг (TAF)	28,000.0
4	Өндрийн салхины урьдчилсан мэдээ	24,100.0
5	Хөөрөлтийн урьдчилсан мэдээ	14,400.0
6	Нислэгийн бүсийн урьдчилсан мэдээ	14,400.0
7	Чиглэлийн урьдчилсан мэдээ	17,200,0
8	Дунд болон өндрийн нислэгийн аюултай үзэгдлийн мэдээ (SIGMET)	39,600,0
9	Нам өндрийн нислэгийн аюултай үзэгдлийн мэдээ (AIRMET)	81,700,0
10	Хиймэл дагуулын болон Радарын бодит ажиглалтын мэдээ, цаг агаарын зураг	2,000,0

Жич: Нэг мэдээний зардлыг ханшийн зөрүү, инфляцын өсөлттэй уялдуулан тооцов.